



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А167

Бор-Өндөр сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын 2026 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “1-2 дугаар багуудад явган хүний зам хийх” ажилд явцын хяналт тавьж, хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч

У.Пүрэвсүрэн

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга

И.Энхтуяа

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

Гишүүд:

Э.Эрдэнэбат

“Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ-ын дарга

Д.Цэнд-Аюуш

Засаг даргын Тамгын газрын нярав

С.Угтахбаяр

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Э.Баяр

Иргэний төлөөлөл

2. “1-2 дугаар багуудад явган хүний зам хийх” ажлын явцын хяналт тавьж, хүлээн авч зохих хууль, журмын дагуу ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (У.Пүрэвсүрэн) -д даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ